

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр, Мягмал гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга** 0

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-4

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 5-29

---

1. “Шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл 5-6
2. Малын индексжуулсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 6-27
3. “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл 27-28
4. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл 28-29

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 21 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилоттой: П.Батчимэг;

Чөлөөтэй: Ц.Мөнхбат, З.Мэндсайхан, Б.Найдалаа, А.Ундраа;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг, Н.Наранбаатар,

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг үг хэлж, хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа “Шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт хэлэлцэх тухай горимын санал гаргав.

**Б.Бейсен:** Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 14

71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Замирагийн “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан горимын санал дэмжигдсэн тул “Шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт хэлэлцэхээр тогтов.

**Нэг. “Шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн “Шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хаалттай горимоор хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Б.Бейсен:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 4

Бүгд: 14  
71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 09 цаг 23 минутаас 09 цаг 55 минутад хаалттай хуралдааны горимоор хэлэлцэв.

**Хоёр.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Гарамханд, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын ахлах референт Н.Батцэцэг, мөн газрын референт Э.Сайнзаяа, “Үндэсний давхар даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, М.Ганхүлэг, Г.Ганбаатар, Б.Уянга, Б.Бейсен нарын тавьсан асуултад “Үндэсний давхар даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, М.Ганхүлэг, С.Замира, Г.Ганбаатар, Б.Бейсен нар үг хэлэв.

**Б.Бейсен:** Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

**Гурав.“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”  
Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Бейсен танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Бейсен:** “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

**Дөрөв.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Бейсен танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын М.Ганхүлэгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Бейсен хариулж, тайлбар хийв.

**Б.Бейсен:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны нээлттэй хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 01 минут үргэлжилж, 24 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 70.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 22 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр, Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 09 цаг 21 минут

### БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Бейсен:** Эрхэм гишүүд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 58,3 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдааны ирцийг танилцуульяа. Буланы Бейсен ирсэн байна. Телеуханы Аубакир ирсэн. Жигжиidийн Батжаргал ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ ирсэн. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн. Сонгобайн Замира гишүүн ирсэн. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн. Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн. Ренчинбямбын Сэддорж гишүүн ирсэн. Болдын Уянга гишүүн ирсэн. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн.

Хэлэлцэх асуудлыг танилцуульяа.

1 дахь нь Байнгын хорооны тогтоолын төсөл “Шинжээч томилох тухай”, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2025 оны 1 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

2 дахь нь Байнгын хорооны тогтоолын төсөл “Шинжээч томилох тухай”

3 дахь нь Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

4 дэх нь Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай”

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу. Ганхүлэг гишүүн.

**М.Ганхүлэг:** Хэлэлцэх асуудалтай холбогдолтой эхний асуудал дээр зохион байгуулалтын бас ажил байх шиг байна. Тийм учраас цагаа хэмнээд, дараагийнхаа асуудлаасаа эхлээд хэлэлцээд явах саналтай байна.

**Б.Бейсен:** Дараалалд өөрчлөлт оруулах тухай санал хураачихъя. Сая нөгөө 2 дахь асуудал “Шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн асуудлыг эхний асуудлаар хэлэлцье. Санал хураалт. 71,4 хувиар дэмжигдсэн. Замира гишүүнийг дэмжсэнээр аваарай.

“Шинжээч томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл 2 дахь асуудал.

Чинбүрэн гишүүн горимын санал гаргаяа.

**Ж.Чинбүрэн:** Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Манай энэ Байнгын хорооноос батлагдсан Утааны сонсголтой холбоотой утааны сонсголыг зохион байгуулах ажлын хэсгээс шинжээч томилулахаар хүсэлт өгсөн байгаа. Шинжээч бол бас нөгөө нууцлалтай байдаг. Бид шинжээчийн нэр усыг олон нийтэд зарлаад, энэ хүн ийм шинжилгээ, судалгаа хийх гэж байгаа шүү гэж зарлах нь өөрөө зохисгүй байдаг. Мөн Их Хурлын түр хорооны хянан шалгах тухай хуульдаа бас энэ асуудал орсон байдаг учраас хурлыг хаалттай явуулж өгөхийг хүсье. Яг зөвхөн энэ хэлэлцэх асуудал дотроо л.

**Б.Бейсен:** Горимын саналаар санал хураалт явуулчихъя. Чинбүрэн гишүүний гаргасан саналаар хуралдааныг хаалттай явуулья гэснээр санал хураалт явуулья. 71.4 хувиар дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай явуулья.

09.23 цаг.

**Малын индексжуулсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.**

Одонтuya сайд танилцуулья.

**С.Одонтuya:** Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын зүгээс Малын индексжуулсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдах хуулийн төслийн хамт боловсруулан өнөөдөр та бүхэнд танилцуулж байна.

Зуд болон бусад гэнэтийн эрсдэлээс малчдын амьдралын баталгаа болсон мал сүргийг хамгаалах зорилгоор Засгийн газар нь Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр малын индексжуулсэн даатгал төслийг 2005 оноос 2014 он хүртэл 10 жилийн турш амжилттай хэрэгжүүлж, улмаар Малын индексжуулсэн даатгалын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2014 онд баталж байсан.

Ийнхүү Малын индексжуулсэн даатгалын хууль хэрэгжиж эхэлснээс Монгол Улсад малчдын гамшигийн эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцооны суурь тавигдсан. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх даатгалын тогтолцоо нь эрсдэл тохиолдсоны дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс зардал багатай, тогтвортой, үр дүнтэй байдаг нь олон улсад нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд байгалийн гамшиг их хэмжээний эрсдэлийн эсрэг хэрэглэдэг даатгалын шинэлэг төрөл юм.

Монгол Улсад малын индексжуулсэн даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлснээс хойш давхардсан тоогоор нийт 267 мянган малчин өрх болон мал бүхий иргэний 59,4 сая толгой малыг индексжуулсэн даатгалд хамруулж, 65 мянган малчин өрхөд 26,1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгоод байна. Хэдийгээр малын даатгалын эрх зүйн орчныг шинээр бүрдүүлж, индексжуулсэн даатгалыг амжилттай нэвтрүүлсэн боловч жилд дунджаар нийт малчин өрхийн дөнгөж 11-18 хувь, нийт малын 7-10 хувь тус тус даатгалд хамрагдаж байгаа нь эрх зүйн орчныг шинэчлэн баталж хэрэгжүүлж байгаа төрийн бодлогын зорилт төдийлөн оновчтой хангагдахгүй байгааг харуулж байна.

Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, малчдын мал сүргийг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Засгийн газраас Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд дараах өөрчлөлтуүдийг оруулахаар боловсруулаад байна. Үүнд:

1 дүгээрт, даатгалын нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг хуульчилсан байгааг өөрчлөн уян хатан тогтоох. Энэ нь малын индексжүүлсэн даатгалын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар малчдын даатгалд хандах итгэл үнэмшлийг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

2 дугаарт, даатгалын нөхөн төлбөрийг гэрээний хугацаанд дараа жилийн намар буюу хохирол гарсны дараа олгодог байсныг өөрчилж, нөхөн төлбөрийг хэсэгчлэн, урьдчилан олгох шинэлэг зохицуулалтыг тусгаад байна.

Ийнхүү нөхөн төлбөрийг урьдчилан олгосноор малчдын амьжиргааны эх үүсвэрт дэмжлэг үзүүлэх, нөгөөтээгүүр үргэлжлэн тохиолдож болзошгүй зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэх юм.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Бейсен:** Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны өнөөдрийн хуралдаанд оролцох ажлын хэсгийн гишүүдийг танилцуулья.

Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга. Сонор байна уу. Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга байна уу. Гарамханд Сангийн яамны Санхүүгийн зах зээл даатгалын хэлтсийн мэргэжилтэн, Батцэцэг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын ахлах референт, Сайнзаяа Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын референт, Жавхлант “Үндэсний Давхар Даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал, Шинэзул “Үндэсний давхар Даатгал” ХК-ийн ахлах мэргэжилтэн, Мөнхбилэг “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Ерөнхий андэйррайтер.

Асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Ганбаатар гишүүнээр тасалъя. Идэрбат гишүүнээр тасалъя. Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль орж ирж байна. Ер нь бол Монгол Улсын хэмжээнд Монголын нөхцөл байдал, эрс тэс уур амьсгалтай, тэгээд мал аж ахуйтай энэ нөхцөл байдалд уг нь индексжүүлсэн даатгал маань маш сайн ажиллах ёстой юм л даа. Тэгээд өнөөдрийг хүртэл ер нь бараг л хэрэгжээгүй гэж хэлж болохоор ийм хууль байгаад байгаа юм. Тэгээд сая хэллээ. Индексжүүлсэн даатгалынхаа төлбөрийг урьдчилсан байдлаар төлнө гээд танилцуулга явчихсан байх юм. Урьдчилан төлнө гээд. Тэгээд энэ урьдчилан төлнө гэдгийг ямар учиртай юм гэдгийг хэлж өгөөч. Урьдчилж, бүр урьдчилаад төлчихнө гэсэн утга бол байж болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг тайлбар авмаар байна.

2 дугаарт, урьд өмнө ер нь яагаад тэр болгон хэрэгжиж ирж чадаагүй юм бэ. Малчдадаа байгаад байгаа юм уу, эсвэл даатгалын компанидаа байгаад байгаа юм уу. Хууль нь эсвэл ерөөсөө буруу, заалт юмнууд нь буруу, амьдралд

хэрэгжихгүй ийм хууль болчоод байсан уу. Мэргэжлийн үүднээс Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй яам энэ дээр сайхан танилцуулга хийгээдхээч. Яагаад урьд нь ерөөсөө тэр бүр хэрэгжиж чадаагүй юм бэ гэдэг дээр ямар дүгнэлт та бүхний хувьд гарсан юм бэ гэдэг дээр хариулт аваадахъя.

**Б.Бейсен:** 7 номер хариулъя.

**Б.Жавхлант:** Сайн байцгаана уу, гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Жавхлант.

1 дүгээрт нь энэ нөхөн төлбөрийг урьдчилан олгох эрх зүйн орчныг энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулах гэж байгаа юм. Учир нь юу вэ гэхээр зэрэг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу хагас жилийн мал тооллогын дүнгийн дараа нөхөн төлбөрийг сумдын том малын зүй бус хорогдлын дүн, статистик тоог үндэслээд нөхөн төлбөр олгодог ийм тогтолцоотой. Энэ хагас жилийн мал тооллогын дүн маань үндсэндээ 7 сард эцэслэгдээд, 8 сард Хамтын эрсдэлийн сангийн хурлаар ороод, ингээд 9-10 сарын хооронд даатгалын нөхөн төлбөр олгогддог юм. Энэ нь болохоор зэрэг үндсэндээ нөгөө даатгалын нэгдүгээрт ач холбогдол, хоёрдугаарт нь даатгуулагч малчин иргэдийн сэтгэл ханамжийн хувьд нэлээн доогуур хэмжээнд байх тийм нөхцөлийг бүрдүүлдэг учраас Үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа явцын мэдээг үндэслээд тухайн сум, орон нутагт босго үзүүлэлтийн 50-аас дээш хувь давсан тохиолдолд нөхөн төлбөрийг 1 удаа урьдчилан нөхөн төлье гэдэг ийм хуулийн зохицуулалт орж байгаа юм.

Тэгэхээр ингэснээрээ бол яг тухайн цаг үед нь гамшигийн эрсдэлийн үед нь малчид нөхөн төлбөр авах боломжийг энэ хуулийн өөрчлөлтийн дагуу олгож байна гэж ойлгож болно.

Хоёрдугаарт нь энэ хууль яагаад өнгөрсөн арван жилийн хугацаанд хэрэгжилт бага байсан бэ гэдэг асуудал дээр өнгөрсөн жил Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дээр Их Хурлын ажлын хэсэг байгуулагдаад, үүнтэй холбоотойгоор 21 аймаг Засаг дарга нараас санал авсан байгаа. Энэ дээр бол ихэнх ирж байгаа саналын бараг 90 хувь нь босго үзүүлэлт өндөр байна гэдэг ийм асуудал дэвшиүлсэн юм. Үүнтэй холбоотойгоор “Үндэсний давхар даатгал” болон Сангийн яамны зүгээс тодорхой тооцоо, судалгаануудыг хийгээд үзэхээр зарим аймгийн зарим сумдад 6-аас доош хувийн босго үзүүлэлт тогтоох боломж байгаа байхгүй юу. Тэгтэл хуульдаа баригдаад бид нар 6 хувиасаа доош нь буулгаж болдоггүй ийм хатуу заалттай байгаад байгаа юм. Тэгэхээр энийг Засгийн газарт энэ эрхийг нь олгосноороо босго үзүүлэлтийг уян хатан тогтоох энэ боломжийг бий болгож, малчдыг даатгалд хамруулах нэг хөшүүрэг болох юм гэж бид нар хүлээж байгаа юм. Баярлалаа.

**Б.Бейсен:** Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ерөнхийдөө бол 10 жилийн хугацаанд тэр болгон хэрэгжиж чадаагүй ирсэн. Үүнийг бас засах нь зүйтэй байсан юм. Урьдчилан гэдгийгээ нэг сайхан тодруулаад өгөөч. Одоо ер нь бол зүгээр эрсдэл гарчихлаа тийм үү. Тэрний тооцооллыг хийж байж асуудлууд чинь шийдэгдэх ёстой шүү дээ. Тэгээд та хэд урьдчилан гээд байх юм. Тэгэхээр чинь юунаас урьдчилж хийх гээд байгаа юм

бэ. Юунаасаа урьдчилж төлбөрөө хийх гээд байгаа юм. Энэ дээр нэг тодруулаад өгөөч.

**Б.Бейсен:** 7 номер хариулья.

**Б.Жавхлант:** Одоо байж байгаа, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль хагас жилийн мал тооллогын дүнгийн дараа нөхөн төлбөрийг олгож байгаа. Түүнээс өмнө YCX-оос явцын мэдээ буюу том малын зүй бус хорогдлын явцын мэдээг сар болгон, улирал болгон гаргадаг ийм статистик тоо гаргадаг юм байна. Тэгээд тэр дээр үндэслэж байгаад хэрвээ тухайн аймаг, орон нутаг, сумд, ялангуяа сумын хэмжээнд гэсэн үг шүү. Том малын зүй бус хорогдлын хэмжээ босго үзүүлэлтийнхээ 50-аас дээш хувьд давсан тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг хагас жилийн мал тооллогыг хүлээлгүйгээр тухайн цаг үед нь нөхөн төлбөрийг YCX-оос гаргасан статистик тоонд үндэслэж олгоё гэсэн ийм зохицуулалт явж байгаа юм.

**Б.Бейсен:** Тодорхой хариулаарай. Асуултад. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль. Энэ дээр нэг ийм заалт байна.

12 дугаар зүйл дээр малчинд үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ буюу арилжааны банкны зохицуулалттай холбоо бүхий асуудал дээр зээл гэсэн үг.

12.3.5.Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан байх гэдэг заалтыг шинээр оруулж ирж байна л даа. Уг нь бол энэ хуулийн зорилт нь малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, төрөөс тавих хяналт, даатгалын эрсдэлийг хуваарилах, нөхөн төлбөр төлөх, малын давхар даатгал, даатгагч болон даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байгаа юм. Арилжааны банкны асуудал бол арилжааны банкны л асуудал. Барьцаагаа авч байгаа. Арилжааны банк дотооддоо тухайн зээл олголттой холбоотой ямар журам гаргана, тэр журмаараа л явах ёстой. Саяхан жолоочийн даатгалтай холбоотой асуудал дээр нэлээн олон асуудлууд бас нийгэмд үүссэн. 2011 онд батлагдсан хууль. Жолоочийн даатгалын тухай 2011 оны хууль дээр бол албан журмын даатгал гэдгээр нь хуульчлаад өгчихсөн байхгүй юу. Одоо энийг ингээд харахаар үндсэн суурь шалтгаануудын 1 нь тэр доор явж байх шиг байгаа юм. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн ерөнхий мэдээлэл дээр гэсэн хэдий ч тус даатгалд дунджаар нийт малчин өрхийн 11-18 хувь л хамрагддаг ба нийт малын 7-10 хувийг даатгуулж байгаа нь төрөөс авч хэрэгжүүлж буй бодлогын зорилтыг хангахгүй байгаа тул хууль тогтоомжид тодорхой өөрчлөлт, шинэчлэлтийг хийх шаардлагатай байна гэж. Та нар одоо ингээд яг энэ арилжааны банкнуудын зээл олголттой процессоор дамжуулаад Малын индексжүүлсэн даатгалыг албан журмын даатгал болгох гэж байгаа юм уу. Энэ чинь банкны асуудал шүү дээ. Төрийн банкнаас ч олгогдож байгаа зээл биш. Тэгээд ингээд бүр малын индексжүүлсэн даатгалд заавал хамрагдсан байх ёстой гэдэг ийм заалт оруулж ирээд, дараа нь энэ тодорхой төлбөр мөнгөтэй, хураамжтай холбоотой асуудлууд шинэчлэгдээд явчихвал наадах чинь асуудал үүсгэнэ. Банкны асуудлыг банканд нь үлдээ гэдгийг би хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарх нь нэг ийм юм байна. Энэ YCX-оос хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг зохион байгуулж, малын хорогдлын дүн мэдээ гарсны дараа малчдад олгох нөхөн төлбөрийг тооцоолж, дараа оны 10 дугаар сард нөхөн төлбөрийг олгодог. Энэхүү хугацаанд зудын эрсдэл болж дууссаны дараа намар нөхөн төлбөр олгогдож байгаа нь зудад өртсөн малчдад гамшигийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөн тэсвэрлэх боломжийг бууруулж байна гэж. Энийг та нар хууль дээр ямар зохицуулалтаар, ямар зүйл заалтаар оруулж өгөх боломжтойгоор хийж байгаа юм бэ.

Гуравдугаар асуулт нь гамшигт үзэгдэл болж байх үед ... би нэмэлт 1 минут авчихъя. Гамшигт үзэгдэл болж байх үед эрсдэлийг бууруулах зорилгоор малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрийн тодорхой хувийг малчдад урьдчилж олгох, ингэхдээ статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын сар бүрийн мэдээнд үндэслэн босго үзүүлэлтийг 50 хувиас дээш давах нь тодорхой болсон тохиолдолд нөхөн төлбөрөөс урьдчилан олгох, хагас жилийн түүвэр судалгааны дүн мэдээ эцэслэн гарсны дараа нөхөн төлбөрийг эцэслэх байдлаар зохицуулах боломжтой гэж оруулсан байгаа юм. Заасан байгаа юм. Энийг та нар хууль дээр ямар зүйл заалтаар ямар боломжоор нь оруулж ирж байгаа вэ гэдгийг би асууя. Тэгээд дараа нь тодруулья. Баярлалаа.

**Б.Бейсен:** 7 номер. Асуултад тодорхой хариулъя. 7 номер.

**Б.Жавхлант:** Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт орж байгаатай холбогдуулаад дагаж орж байгаа хуулийн өөрчлөлт нь Малчны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.5-д өөрчлөлт орж байгаа. Энэ бол 12.3.5 дугаар зүйл бол арилжааны банкнаас олгож байгаа малчдын хэрэглээний зээлтэй холбоотой зохицуулалт бол биш юм байгаа юм. Тэгээд энэ үндсэндээ бол Засгийн газраас олгож байгаа нэн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамрагдаж байгаа малчин өрх заавал даатгалд малаа даатгуулсан байх ийм шаардлагыг оруулж ирж байгаа.

Үндсэн зорилго нь юу вэ гэхээр зэрэг тухайн нэн хөнгөлөлттэй зээлийг буцаан төлөх санхүүгийн гол эх үүсвэр нь бол нөгөө мал сүрэг байгаад байгаа. Тэгэхээр зэрэг түүнийг даатгалд хамруулж, зээлийнхээ эргэн төлөлтийн баталгаажуулалтыг хангаснаараа зээлийн ялангуяа зөвхөн Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж байгаа нөхцөлд энэ хуулийн зүйл, заалт үйлчилнэ.

Төрийн банк болон Хаан банкнаас малчдад олгож байгаа хэрэглээний зээлүүд дээр малын индексжүүлсэн даатгалыг албан журмаар даатгалд хамруулдаггүй. Зөвхөн даатгуулагч буюу зээл авч байгаа иргэн маань өөрөө хүссэн тохиолдолд даатгалд хамрагддаг ийм зохицуулалт одоо явж байгаа.

Хоёрдугаарт нь болохоор зэрэг энэ хагас жилийн мал тооллогын дүн гарсны дараа даатгалын нөхөн төлбөрийг олгодог. Өөрөөр хэлбэл энэ маань хагас жилийн мал тооллого бол үндсэндээ 7 сард эцэслэгдэж дуусдаг. Үүний дараа 8, 9 сард даатгалын нөхөн төлбөр олгогдож байгаа юм. Тэгэхээр энэ нь бол үндсэндээ бол тухайн гамшигийн эрсдэлийг хөнгөвчлөх зорилгодоо бүрэн дүүрэн хүрч чадахгүй байна гэж үзэж байгаа учраас энэ даатгалын нөхөн төлбөрийг YCX-оос гаргасан явцын мэдээнд үндэслээд нөхөн төлбөрийг 1 удаа урьдчилан нөхөн төлбөр олгож болно гэсэн ийм зохицуулалт байгаа. Одоо байж байгаа хууль

дээрээ даатгалын нөхөн төлбөрийг хэсэгчилж олгохыг хориглоно гэсэн ийм заалттай учраас нөхөн төлбөрийг явцын мэдээнд үндэслэж нөхөн төлбөр олгож болдоггүй ийм хатуу зохицуулалттай байгаад байгаа учраас үүнийг өөрчлөх замаар энэ нөхөн төлбөрийн зохицуулалтыг уян хатан болгож байгаа юм.

**Б.Бейсен:** Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

**Б.Бат-Эрдэнэ:** Малчны тухай хуулийн 12 дугаар зүйл. Малчинд үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ.

12.2. арилжааны банканд малчинд зориулсан нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй зээлийн болон даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний шинэ нэр төрлийг нэмэгдүүлж, малчин үйлдвэрлэлдээ чанарын өөрчлөлт гаргах, байгальд ээлтэй тогтвортой үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.

12.3. Энэ хуулийн 12.2-т заасан зээлийг арилжааны банкны болон доор дурдсан шаардлагыг хангасан малчинд олгоно гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл нэн хөнгөлөлттэй, хөнгөлөлттэй зээлийн болон даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний шинэ төрлийг нэмэгдүүлэх. Тэгээд энэ чинь та хэд заавал хамрагд гэдэг систем чинь болж байгаа юм уу. Үгүй ээ, тэгээд зээл авах гэж байгаа малчин банкныхаа шаардлагаар өөрсдөө хамрагдах ёстой бол хамрагдаад л.../минут дуусав/

**Б.Бейсен:** 7 номер хариулья.

**Б.Жавхлант:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья. Энэ 12.2 дугаар зүйлд заасан зээлийн бүтээгдэхүүн бол улсын төсвөөс татаас өгч хэрэгждэг зээлийн бүтээгдэхүүн байгаа байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ хуулийн 12.7-д зааснаар улсын төсөвт нэн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг оруулна гэсэн ийм зохицуулалттай байгаа. Тэгэхээр энэ бол зөвхөн улсын төсвөөс санхүүжилттэй олгож байгаа нэн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамрагдах ийм зохицуулалт юм байгаа юм.

**Б.Бейсен:** Асуултад тодорхой хариулаарай. Б.Бат-Эрдэнэ гишүүнд 1 минут олгоё.

**Б.Бат-Эрдэнэ:** Энэ хуулийн чинь нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилсан тандан судлах үнэлгээний тайлан дээр чинь Жавхлантаа бичихээд байна шүү дээ. Чи болохоороо тэр жилийнхээ 7, 8 сар гээд 9, 10 сард олгох тухай яриад байх юм. Энэ урьдчилан олгох гээд энэ бичихсэн дээр чинь дараа оны 10 дугаар сард нөхөн төлбөрийг олгодог гээд бичихээд байна шүү дээ. Тэгээд энэ судалгааны тайлан чинь худлаа гарчхаад байгаа юм уу. Та хэдийн өөрсдийн чинь оруулж ирсэн материал энэ шүү дээ. Өөрөө болохоороо 10 сардаа тэр оныхоо 10 сарын тухай яриад байна. Энэ дээр болохоор дараа оны 10 сарын тухай бичигдээд байна шүү дээ. Аль нь үнэн яриад, аль нь худлаа яриад байгаа юм бэ гэдгийг тодруулчихмаар байна.

Тэр төрөөс олгож байгаа нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээл гэдгийг би төрөөс үзүүлж байгаа үйлчилгээ гэдгийг ойлгож байна. Тэгэхдээ та нар өөрсдөө энийг заавал малын индексжуулсэн даатгалд хамрагдах ёстой гэж заалт оруулж өгч байж энэ үгээрээ та нар албан журмын даатгал шиг процессыг хийж өгчхөөд

байна шүү дээ. Энэ банкнууд өөрсдөө зохицуулалтаа хийгээд явчхаж болдоггүй юм уу л гэж би .../минут дуусав/

**Б.Бейсен:** 7 номер хариулья.

**Б.Жавхлант:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулья. Энэ дээр ийм учиртай юм. Энэ даатгалын гэрээ маань 18 сарын хугацаатай байгуулагддаг юм. Өөрөөр хэлбэл энэ жил даатгалд хамрагдаж байгаа малчин маань ирэх жилийн 2026 оны даатгалын эрсдэлээс өөрийгөө хамгаалж, даатгалд хамрагдаж байгаа гэсэн үг. Тэгэхээр 2025 оны 1 сарын даатгалд хамрагдсан малчны даатгалын хураамж бол 2026 оны өвлийн даатгалын хураамж гэсэн үг. Өнгөрсөн 2024 онд даатгалын нөхөн төлбөр авсан хүмүүс бол 2023 онд даатгалд хамрагдсан хүмүүс даатгалынхаа нөхөн төлбөрийг авч байгаа гэсэн үг л дээ. Өөрөөр хэлбэл зудын эрсдэл бол цаг хугацааны хувьд бол он дамнаж учирдаг ийм онцлог гамшгийн эрсдэл байж байгаа. Тийм учраас даатгалын гэрээг өмнөх жилд нь хийдэг. Тийм учраас энэ дараа оны гэдэг ийм үг ороод байгаа юм.

**Б.Бейсен:** Жигжиидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

**Ж.Батжаргал:** Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл орж ирж байгаа юм. Үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжмээр, хэлэлцүүлгийн тувшинд нэлээн тал бүрээс нь ярилцмаар зүйл. Арав гаруй жил бараг хэрэгжихэж байгаа юм шиг байгаа юм энэ хууль яг батлагдаад.

Тэгээд 37 орчим тэрбум төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлээд, 29 орчим тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгоод, нийт малчин өрхийнх нь арван хэдэн хувь хамрагдаад, малынх нь 9 хувь хамрагдсан нэг ийм л юм гарч ирээд байгаа юм л даа. Тэгээд энэ талаасаа харах юм бол энэ даатгалын ач холбогдол үнэхээрийн чамламаар гэсэн үг. Яах аргагүй уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын давагдашгүй хүчин зүйлийн давтамж нэмэгдчихсэн. Тэгээд уг эрхэлж байгаа аж ахуй нь өөрөө байгалийн нэн хараат аж ахуй учраас үүний эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэл гарсан тохиолдолд эрсдэл хуваадаг тогтолцоог нь бүрдүүлж байж энэ чиглэлийн хүмүүсийнхээ бид амьдралын баталгаа гэдэг юм уу, ядуурлаас гэдэг юм уу хамгаалах ийм л тогтолцоо байх ёстой л доо. Тэгээд энэ зорилгоо бол яг нарийндаа хангаж чадахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр бид энэ хуульд нэлээн том концепцын шинж чанартай өөрчлөлт хийхгүйгээр боломгүй болчхоод байгаа юм.

Өнөөдрийн орж ирчхээд байгаа зүйл бол үндсэндээ хохирлыг бид тодорхой хугацааны дараа тайлан мэдээ, дүн гарсан хойно олгодог байсан юмыг хохирлын хорогдлын мэдээлэл дээр тулгуурлаад явцын байдал дээр нь тулгуурлаад урьдчилсан байдлаар нөхөн олговор олгож болох тухай, тэр нь үлдсэн малыг нь эрсдэлээс хамгаалахад нь нэмэр болно гэсэн санаа юм байна гэж би хараад байгаа юм.

Хоёр дахь нь Улсын Их Хурал уг нь 1 дүгээр босго, 2 дугаар босго дээр хувь зааж өгсөн юм. Малын хорогдлын хувийг. Одоо энэ хувийг байхгүй болгоод Засгийн Газар өөрөө тогтоохоор ийм эрх нээж өгч байгаа юм. Тэгээд нээж байгаа эрх нь даатгалын байгууллагынхаа санал дээр тулгуурлаад гэсэн нэг ийм л үг л яваад байгаа юм л даа. Хэрвээ одоо үүнд иж бүрэн хандья гэвэл хэдүүлээ ядаж

энэ бүсчилдэг гэдэг юм уу мужилдаг байдлаар нь хувь хэмжээг нь босгыг нь тогтоомоор байгаа юм. Хадлан тэжээл гэдэг юм уу, бэлтгэж чаддаг мал нь бас үндсэндээ хагас сууринmallagaаны хэлбэр лүү шилжчихсэн нэг хэсэг бүс нутаг байна шүү дээ. Энд хорогдлын ямар босготой байх юм. Яг цэвэр бэлчээрийн гэдэг юм уу нүүдлийн шинж чанараа агуулаад явж байгаа тэр бүс нутгууддаа ямар босготой байх юм.../минут дуусав/

**Б.Бейсен:** Батжаргал гишүүнд 1 минут сунгая.

**Ж.Батжаргал:** Ийм байдлаар анзаарах бололцоо боломж байна уу гэж нэг ийм зүйл.

Одоо би хууль руу нь ярья. Урьдчилгаа нөхөн төлбөр өгчихдөг юм байжээ та хэд урьдчилаад. Бодит гүйцэтгэл гарахаар яах юм зөрүүг нь яах юм бэ хэдүүлээ. Тэрний талаар бол энэ хуульд заалт байхгүй болчкоод байгаа шүү дээ. Ойлгож байна уу. 2 сард гэдэг юм уу, 3 сард хорогдлын мэдээ дээр тулгуурлаад энэ сумын малын хорогдол 6 давчихсан байна. Тийм учраас даатгуулагч нарт нь хохирол өгчихье гээд өгчих юм байж. 6 сард дүн гарахад өнөө ядарсан мал нэлээн хорогчихсон, нэмээд хорогчихсон байвал тэр эцсийн хохирлыг яаж өгөх юм гэдэг харилцаа энэ дотор орж ирээгүй байгаад байгаа юм. Үүнийг юу гэж та хэд маань төсөөлөөд байна вэ гэж. Хариултаа авч байж явахгүй бол болохоо байлаа л даа.

**Б.Бейсен:** 7 номер хариулья.

**Б.Жавхлант:** Батжаргал гишүүний асуултад хариулья. Нэгдүгээрт нь энэ малын индексжүүлсэн даатгалын босго үзүүлэлт гэдэг энэ суурь үндсэн концепц маань сумын том малын зүй бус хорогдлын хувь дээр сүүлийн 50 жилийн статистик тоонд үндэслэж гарсан ийм тооцоололтой ийм даатгалын бүтээгдэхүүн юм байгаа юм. Үндсэндээ 2005 оноос Дэлхийн банкны мэргэжилтнүүд манай Монгол Улсын даатгалын болоод хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд хамтраад энэ төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг Монгол Улсад шинээр нэвтрүүлсэн. Ийм шинэ тутам даатгалын бүтээгдэхүүн.

Монгол Улсын хэмжээнд 2014 он хүртэл төслийн журмаар хэрэгжээд, цаашдаа хэрэгжих боломжтой юм гээд ингээд гарсан ийм даатгалын бүтээгдэхүүн юм байгаа юм. Одоо мэдээж нөгөө даатгалын бүтээгдэхүүн маань бараг 20 жил болчж байгаа учраас энэ хөшүүргийг нь буюу босго үзүүлэлт, индексийг өөрчлөх шаардлага бол шинжлэх ухааны ололт дэвшилттэй уялдуулаад, түүнийг өөрчлөх боломж бололцоог бид нар олон улсын байгууллагуудтайгаа ялангуяа Дэлхийн банктайгаа хамтраад цаашаа эрэлхийлээд, судалгааны ажил явагдаж байгаа. Өөрөөр хэлбэл мужлал гэхээсээ илүүтэйгээр уур амьсгалын индекс гэдэг юмыг оруулж ирж байгаа гэсэн үг.

Өөрөөр хэлбэл зарим тохиолдолд хүйтэн уур амьсгалын индекс гэдэг юмыг зарим улс орнуудад хэрэгжүүлж байгаа ийм тохиолдолд байдаг юм байна. Түүнийг бид нар бас энэ даатгалын бүтээгдэхүүнтэй уяж, зөвхөн малын хорогдол биш илүү өөр индекс оруулж ирэх боломжийг бол судалгааны түвшинд явагдаж байна.

Хоёрдугаарт нь энэ даатгалын нөхөн төлбөрийг 1 удаа урьдчилан олгоно гэсэн ийм хуулийн өөрчлөлт орж байгаа. Зөрүү буюу том малын хорогдлын too

мэдээ эцэслэн гарсны дараа нөхөн төлбөрийг олгох зохицуулалт маань хэвээрээ явагдаж байгаа. Ийм учраас 2 юм уу, 3 сард гарсан явцын мэдээ дээр олгосон нөхөн төлбөр илүү 5, 6 сард илүү мал хорогдсон тохиолдолд өмнө нь олгогддог процессынхоо дагуу 10 сард даатгалын нөхөн төлбөр маань эцэслэгдэнэ. Нөхөн олгогдоно гэсэн ийм зохицуулалт нь хэвээрээ байгаа.

**Б.Бейсен:** Батжаргал гишүүн тодруулья.

**Ж.Батжаргал:** Давхар даатгалын тогтолцоогоо устгачхамгүй байна. Дөнгөж эхэлж байгаа энэ нэг юм. Энэ бидэнд хэрэгтэй юм нэг.

Хоёрдугаарт энэ малчдыг өргөн хүрээтэй хамрагдах тэр сонирхлыг төрүүлсэн эрх зүйн зохицуулалтыг энэ рүү оруулмаар байгаад байгаа юм. Би сумын хэмжээнд босго тавьж байгааг буруу гэхгүй байгаа. Энэ бол яг нарийндаа малчдын мал маллагааны арга барилтай холбоотой хариуцлага, сахилгатай холбоотой асуудал болоод байгаа байхгүй юу. Нийт иргэд малчид нь малаа их учиргүй хорогдуулчхаагүй байхад цөөвтөр малчид малаа хорогдуулчихсан бол тэрүүнд нөхөн олговор олгохгүй гэдэг үйл явц бол байж болох үзүүлэлт гэж. Гэхдээ 5 жил гэдэг юм уу, 10 жил sumaараа энэ даатгуулагч нар нь хохирол аваагүй тэгж сайн ажилласан бол тэр бус нутгийн даатгалын хураамжийг бууруулдаг ч гэдэг юм уу, эсвэл тэр даатгалын хураамжаар бий болсон хөрөнгөөс тодорхой урамшууллын тэр эрсдэлийг .../минут дуусав/

**Б.Бейсен:** Батжаргал гишүүн 1 минут өгье.

**Ж.Батжаргал:** Дэмжсэн үзүүлэлтийг оруулна ч гэдэг юм уу. Дараагийн нэг анхаармаар байгаа зүйл үнэхээрийн ингэж жоохон урьдчилж юм олгоё энэ тэр гэж бодоод байгаа бол хорогдол дээр тулгуурламгүй байгаа юм. Мэргэжлийн байгууллагууд нь дүгнээд, ноднингийн Сүхбаатарт болсон шиг үйл явцыг 11 сард Онцгой комисс нь тогтоогоод, энэ бол давагдашгүй хүчин зүйл болчихлоо. Одоо энэ малчдыг эрсдэлээс хамгаалах ёстой. 1 хэсэг малыг нь борлуулья, 1 хэсгийг нь тэжээ, 1 хэсгийг нь отор хийлгэе гээд шийдэл гаргах ёстой. Үүнийг нь харин энэ даатгалын байгууллага тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлмээр байгаа юм. Ингэж чадах юм бол нийт гарсан хохиролд өгдөг нөхөн төлбөр чинь буурах, ёстой өнөө хэдэн даатгуулсан малчдаа эрсдэлээс хамгаалахад нь энэ байгууллагын чиглэл явах бололцоо бүрдэх юм биш байгаа даа. Хэдүүлээ энэ тал руу жоохон тэмтэрвэл яах бол. Гэтэл хөндөгдөөгүй гээд ярьж болохгүй болчоод байна л даа. Хамгийн аюултай нь орж ирсэн хуулийн төсөл.../минут дуусав/

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. 7 номер хариулья.

**Б.Жавхлант:** Энэ үндсэндээ бол босго үзүүлэлтийг уян хатан тогтоох, нөхөн төлбөр 1 удаа урьдчилан олгоно гэдэг бол үндсэндээ энэ даатгалын бүтээгдэхүүн дээр болон суурь зохицуулалт нь өөрчлөлт орчиж байгаа нэг хэлбэр мөн л дөө. Яах вэ, саяын бид нарын өнөөдрийн түвшинд оруулж ирж байгаа өөрчлөлт бол үндсэн бүтцээ өөрчлөхөөсөө илүүтэйгээр илүү хамрагдалтыг нэмэгдүүлэх л ийм зорилготой ийм зохицуулалт орж ирсэн юм. 21 аймгаас авсан судалгаагаар бол малчид энэ босго үзүүлэлтийг л бууруулж өгөөч гэсэн нийтлэг хүсэлт тавиад байдаг юм. Энэ нөгөө олон улсын шинжээч нар яг энэ даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулсан олон улсын шинжээч нараас тавьж байгаа санал нь юу вэ гэхээр зэрэг энэ даатгалын бүтээгдэхүүний босго үзүүлэлтийг бууруулж өгснөөрөө

даатгалын хамрагдалтыг өсгөх нэг хүчин зүйл мөн боловч, үндсэн суурь шалтгаан болж чадахгүй. Харин санхүүгийн үйлчилгээ болоод бусад нийгмийн чанартай төрөөс олгож байгаа бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбож өгөх юм бол энэ харин хамрагдалтыг нэмэгдүүлэх нэг том шалтгаан болно гэдэг ийм зохицуулалт байвал зүгээр юм гэсэн ийм зөвлөмжүүдийг өгсөн юм. Тэрэнтэй холбоотойгоор энэ Малчны тухай хуулийн 12.3.5-д орж байгаа өөрчлөлт бол үндсэндээ яг энэ нөгөө хамрагдалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой ийм зохицуулалт орж өгч байгаа л даа.

Тэгэхээр Батжаргал гишүүнтэй санал нэг байна. Энэ даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх асуудал бол зайлшгүй бид нарт тулгарч байгаа асуудал. Үүнтэй холбоотойгоор яг энэ Малчны тухай хуулиас гадна бусад төрлийн хуулиуд татварын болоод бусад хуулиудаар өөрчлөлт оруулах асуудлууд сөхөгдөж болно. Тэгэхдээ яг өнөөдрийн түвшинд бол бид нарын хийсэн тандан судалгааны хүрээндээ бид нар яг энэ босго үзүүлэлтийг бууруулах, нөхөн төлбөрийн урьдчилгаа олгох, Малчин тухай хуульд заасан Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээл, тусlamжид хамрагдсан малчдадаа малаа заавал даатгуулсан байх гэсэн энэ З хүчин зүйлийг оруулж ирснээрээ бас даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бололцоо нэмэгдэх юм болов уу гэсэн ийм судалгааны үндсэн дээр энэ хуулийн төсөл орж байгаа.

**Б.Бейсен:** Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Давхар даатгалтай холбогдолтой асуудал бол малчдын хувьд хамгийн чухал асуудлууд байдаг. Иргэдийн уулзалт, малчдын уулзалт дээр бол хамгийн их гаргадаг асуулт, саналуудын нэг нь. Энэ утгаараа бид нар энэ асуудлыг нэлээн нухацтай бас ярилцах шаардлагууд бас байна. Одоогийн орж ирж байгаа З төрлийн зохицуулалт байна гэж би харж байна. Нөхөн төлбөрийг урьдчилж олгохтой холбогдолтой. Энэ бол бас яг зудын нөхцөл байдлын үед бол бас зөв арга хэмжээ болохоор ийм шийдэл харагдаж байна.

2 дахь нь босго үзүүлэлтийг илүү бууруулах, шинэчилсэн тооцоолол гээд байх шиг байна. Энийг би бас тодруулж асууя гэж бодож байна.

Гурав дахь нь тэр зээлтэй холбогдолтой гээд ийм гурван л өөрчлөлт харагдаж байна л даа. Ерөнхий агуулгаараа бол яг энэ малчдын хүсээд байгаа асуудлууд руу гэхээсээ илүүтэй даатгалын үйл ажиллагаагаа илүү хүртээмжийг нэмэгдүүлж, сайжруулах гэсэн энэ агуулга руугаа л чиглээд байгаа юм шиг ийм өнцөг бол харагдаад байна.

Эхний асуулт нь “Үндэсний давхар даатгал” компанийн үндсэн зорилго нь малчдыг эрсдэлээс хамгаалахынхаа төлөө байна уу, ашгийн төлөө байна уу. Даатгалын компаниуд болон бусад арилжааны банкнуудыг дэмжсэн нэлээн ийм агуулгууд бас орж ирж байгаа. Энэ дээрээ нэг тодорхой агуулгуудыг бол малчдын хүсээд байгаа гол агуулга маань босго үзүүлэлтүүдийг бууруулаад өгөөч гэж та сая хэллээ. Энийг бууруулахдаа 2 л агуулгаар бол хүсээд байгаа юм.

Нэгд бол хамрах хүрээг нь багасгаад өгөөч ээ. Сумын хэмжээнд байгаа үзүүлэлтийг багийнх байдаг юм уу, хамрах хүрээний хувьд бол багасгах ийм боломж байна уу гэдэг дээр.

Хоёр дахь нь хувь хэмжээ 6 хувь орчим байгааг бууруулах боломж байна уу гэдэг ийм тодорхой л асуудлуудыг бол хүсээд байгаа юм л даа. Тэгэнгүйт манайхны оруулж ирж байгаа шийдэл нь болохоор шинэ тооцоолол энэ цаг үетэйгээ нийлсэн ийм тооцоолол энэ тэр гэдэг ийм байдлаар улам л тодорхойгүй, улам л ойлгомжгүй болохоор малчид маань яж хүртээмжээ нэмэгдүүлж, илүү их хамрагдалтад бий болгох вэ гэдэг ийм эргэлзээ бас орж ирэхээр байна. Тэгэхээр энэ чиглэлийн агуулгаар нь бас та бүхэн жоохон дэлгэрүүлж бас мэдээлэл өгөх нь зөв гэж бодож байна.

Дээрээс нь бол зарим энэ агуулгуудыг сайн судлах хэрэгтэй. Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал нь орж ирэхдээ бол зайлшгүй арилжааны банканд болон бусад санхүүгийн үйлчилгээ авахдаа бас давхар даатгалд хамрагдсан байх ёстой гэдэг ийм албан журмаар даатгуулах шаардлагатай юм шиг ийм агуулга орж ирж байгааг гишүүд хэлж байна. Тэгээд энэ дээр бол бид нар бол нэлээн ярилцах шаардлага үснэ гэдгийг бол адилхан саналтай байна. Тэгээд энийг бол бүгдээрээ бас эргүүлж харах ёстой байх. Тэгэхээр энэ хэлэлцүүлгүүдийг ямар түвшинд зохион байгуулав. Өнгөрсөн хугацаанд бас тодорхой бус нутгуд дээр ямар үр дүнтэй байдлууд гарсан. Үүнд ямар дүгнэлтүүд хийж энэ саналыг оруулж ирсэн бэ гээд ерөнхий ийм асуултууд..../минут дуусав/

#### **Б.Бейсен:** 7 номер хариулья.

**Б.Жавхлант:** Ганхүлэг гишүүний асуултад хариулья. “Үндэсний давхар даатгал” ХК бол Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасны дагуу байгуулагдсан ашгийн төлөө ХК байгаа.

Малын индексжүүлсэн даатгалын хуульд заасан бидний яриад байгаа энэ малын индексжүүлсэн даатгалын тогтолцоо бол гамшгийн хамтын эрсдэлийн санг энэ хуулийн дагуу бий болгосон юм. Хамтын эрсдэлийн сан гэдэг маань юуг ойлгоод байна вэ гэхээр зэрэг даатгалын компаниудын хураамжийн орлогыг гамшгийн эрсдэлийн сан хэлбэрээр цуглуулаад, энийгээ арвижуулах замаар гамшгийн эрсдэлийн хохирлыг нөхөн төлдөг. Өөрөөр хэлбэл төр, хувийн хэвшлийн хамтарсан жишиг ийм загварыг гамшгийн эрсдэлийн менежментийн жишиг загварыг энэ хуулийн дагуу бий болгож чадсан гэж ойлгогддог. Олон улсын шинжээчдийн зүгээс энэ бас нэлээн сайн үнэлгээтэй ийм тогтолцоо байдаг. Ийм учраас энэ бол хувийн хэвшлийг оролцуулаад, яг энэ даатгалын зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор даатгалын тогтолцоо маань явж байгаа гэдгийг бол нэгдүгээрт тодруулах ёстой.

Хоёрдугаарт нь босго үзүүлэлт гэдэг бол үндсэндээ даатгалын энэ бүтээгдэхүүний үндсэн шийдэл нь байгаа гэсэн үг. Тэгэхээр энийг өмнө нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээр 1 дүгээр босго үзүүлэлт 6 хувь, 2 дугаар босго үзүүлэлт 30 хувь байна гээд ингээд хатуу тогтоогоод өгчихсөн байгаа. Гэтэл одоо 6-аас доош малын хорогдолтой, хэвийн хорогдол нь 6-аас доош хэмжээнд байдаг сумд улсын хэмжээнд бол 40 гаруй ийм сумд байгаад байгаа байхгүй ю. 6-аас доошоо. Тэгэхээр эдгээр лүү ингээд босго үзүүлэлтийг уян хатан болгож бууруулж орж ирье гэхээр зэрэг нөгөө 6 гэдэг дээрээ баригдчихаад хөдөлж болдоггүй. Ийм учраас олон жилийн малын хорогдлын дүн мэдээнд үндэслээд, Засгийн газар сумын малын хорогдлын хэмжээ, даатгуулагчдын тоо энэ даатгалд хамрагдалтын хэмжээтэй уялдуулаад даатгалын босго үзүүлэлтийг өөрчлөх,

өөрчлөхдөө актуарын тооцооллын үндсэн дээр босго үзүүлэлтийг өөрчлөх ийм боломж бололцоог нээж өгье гэсэн ийм зорилготой зүйл, заалт гэж ойлгож болно.

Гуравдугаарт, энэ хуулийг боловсруулахтай холбоотойгоор 2023 оны 8 сараас эхлээд Улсын Их Хурлын дэргэд ажлын хэсэг байгуулагдаад, 21 аймгийн Засаг дарга нараас саналыг аваад, мөн түүнчлэн өнгөрсөн жил яг гамшигийн эрсдэлийн үеэр “Үндэсний давхар даатгал” болоод Сангийн яамны зүгээс хөдөө орон нутагт ажиллахдаа малчдаас авсан санал асуулга, НҮБ-ын ХХААБ-ын хийгдсэн 10 мянга орчим малчдын дунд хийгдсэн амьжиргааны тувшин болон эрсдэлийн удирдлагатай холбоотой санал асуулгын дүн, мөн түүнчлэн шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбоотойгоор хөдөө орон нутагт ажиллах явцад гарсан санал санаачилгуудын дүн мэдээг үндэслэж өдгээр тооцооллууд бол хийгдсэн байж байгаа. Мөн түүнчлэн энэ хуулийн төслийг боловсруулсантай холбоотойгоор салбарын буюу даатгалын мэргэжилтнүүдийн болон төрийн байгууллагуудын хооронд хоёр удаагийн хэлэлцүүлэг хийгдсэн. Дээрээс нь 2024 оны 12 дугаар сард 21 аймгийн малчдын төлөөлөл оролцсон малчны зөвлөгөөнийг Төрийн ордонд зохион байгуулсан. Үүнтэй холбоотойгоор ирсэн санал, зөвлөмжүүдийг тусгасан байж байгаа.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн тодруулья.

**М.Ганхүлэг:** Тийм ээ, үндэсний давхар даатгалын зорилго маань яг зорилгынхоо төлөө л бас саналууд орж ирээд байна л даа. Яг малчдын энэ цаг уурын нөхцөл байдал, эрсдэлээс хамгаалахтай холбогдолтой, яг ашгийн төлөө биш тодорхой асуудал дээр нь ингээд шийдүүлээд гаргаад явдаг ийм бас даатгалын бусад төрлийн тогтолцоонууд ер нь байж болох уу. Тэгээд тодорхой олсон ашгаа саяын бас гишүүдийн гаргаж байгаа саналтай адилхан олон жилийн идэвхтэй даатгуулж байгаа иргэддээ буцаан урамшуулал болгож олгодог энэ тэр гэдэг ийм шинэ механизмуудыг бий болгоод ингээд явдаг байдлаар бас сайжруулах энэ боломжууд бас байж болох уу гэдэг талаас нь Хүнс, хөдөө аж ахуй яаман дээр энэ салбарын бас даатгалтай холбогдолтой асуудлуудыг яаж явах вэ гэдэг талаас нь би бас нэмэлт асуултыг бол асууя. Яг тодорхой зүүн бүс дээр өнгөрсөн хугацаанд сүүлийн 2 жилийн хугацаанд нэлээн хүнд өвлийг давсан. Үүнтэй холбогдолтой нөхөн төлбөр олгосонтой холбогдолтой мэдээллийг та бас яг энэ өөрчлөлттэйгөө холбоод танилцуулаач.

**Б.Бейсен:** 7 номер хариулья.

**Б.Жавхлант:** Энэ даатгалын тогтолцоо бол саяын хэлсэнчлэн Хамтын эрсдэлийн даатгалын сангийн тогтолцоо бол одоо яг төр, хувийн хэвшлийн хувьд хамтын ажиллагааны үндсэн суурь зарчим дээр тулгуурлаж байгаа. Тэгэхээр хувийн хэвшлийн даатгалын компаниуд бол малын индексжүүлсэн даатгалын экосистемийн нэг үндсэн оролцогч этгээд байгаа. Ингэж явж байж даатгалын зарчим маань зөв хэрэгжиж байгаа гэж бид нар харж байгаа. Үндсэндээ мал аж ахуй ялангуяа мал аж ахуйн салбарт олон улсын жишгийг аваад үзэх юм бол хөдөө аж ахуйн салбарын зорилготой гамшигийн эрсдэлийн даатгалын бүтээгдэхүүний хувьд төр зайлшгүй татаас хэлбэрээр ямар нэгэн санхүүжилт олгодог ийм олон улсын жишиг байдаг юм байна. Ер нь бол жишээ нь Казакстан Улс гэхэд малын даатгалынхаа 50 хувийг .../минут дуусав/

**Б.Бейсен:** 7 номер гүйцээж хариулья.

**Б.Жавхлант:** Малчны хураамжийн 50 хувийг төр даадаг, Киргиз бол 80 хувийг төр даадаг гэх мэтчилэн ийм зохицуулалтууд байдаг юм байна лээ. Монгол Улсын хувьд бол яг Засгийн газраас татаас хэлбэрээр ямар нэгэн тийм санхүүжилт бол олгогддоггүй. Зөвхөн “Үндэсний давхар даатгал” компанийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нөөцийн сангаар нөхөн төлбөр олгогддог ийм зохицуулалттай.

Мэдээлэл болгож хэлэхэд “Үндэсний давхар даатгал” ХК 2023 оны хувьд бол 4,2 тэрбум төгрөг, 2024 оны хувьд 16,8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг нийтдээ 37 мянга орчим малчинд олгочихсон. Энэ нь болохоор “Үндэсний давхар даатгал” компанийн дээд, дунд түвшний эрсдэлийн санг үндсэндээ шавхаж дууссан байж байгаа. Ингэж нөөцийн сан маань хорогдсон ч гэсэн “Үндэсний давхар даатгал” компани өөрийн..../минут дуусав/

**Б.Бейсен:** Ганбаатар гишүүн асуулт асууя. Гомбын Ганбаатар гишүүн. З

**Г.Ганбаатар:** Өнөөдрийн энэ ярьж байгаа асуудал хөдөө аж ахуйн салбарт, ялангуяа эрсдэл өндөртэй салбарт маш чухал зүйл байгаа юм. Ялангуяа энэ мал аж ахуй бол сүүлийн цаг үед эрсдэлийн давтамж маш өндөр болж байгаа үед бол давхар даатгалын асуудал чухал. Зүгээр харамсалтай нь яах вэ, нөгөө ниргэсэн хойно нь хашхирав гэдэг шиг өнгөрсөн жил 8,2 сая малаараа толгой тахиж байж л ойлгож байх шиг байна. Тэрбум гаруй долларын зөвхөн хөдөө аж ахуйн салбарт учирсан нь тэрбум гаруй доллар юм байна лээ шүү дээ. Дээрээс нь нөгөө улсын нөөцөөс гаргаад, давхар улс төрчид давхилдаад байсан тэр нь хэд болсон мэдэхгүй.

Гол 2 юм орж ирж байгаа юм байна. Тэр босгын асуудал, даатгалын босго үзүүлэлт, нөхөн төлбөрийг бол явцын дунд олгоё гээд. Яах вэ, 1 асуулт нь сая бараг “Үндэсний давхар даатгал” Жавхлант гэсэн үү өөрөө, ярианд нь бараг гарах шиг боллоо. Миний асуулттай холбоотой Үндсэн хуулийн заалт “Мал сүрэг үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж. Яг энэ агуулгаараа бол үнэхээрийн төрийн хамгаалалтад байх ёстой юм бол төрөөс 50 хувийнх нь даатгалын хураамжийг төлөөд, малчин 50 хувийнхаа даатгалын хураамжийг төлөх ёстой байхгүй юу. Нэгэнт Үндсэн хуулийнхаа энэ заалтыг байлгая гэж байгаа бол. Яг энэ рүү нь энэ хуулийн агуулга явах ёстой. Тэгвэл энэ маш эрсдэлгүй, бас их зөв голдирол руугаа орох юм. Энэ тал дээр бас сая хэлж байна. Зүгээр энэ дээр тийм боломж байгаа юу. Мэргэжлийн хүний хувьд. Бодвол мэргэжлийн хүмүүс л энд сууж байгаа байлгүй. Хүнс, хөдөө аж ахуй яамныхан байна.

Хоёр дахь зүйл нь өнгөрсөн жил бас малчдад хүндрэл учруулсан зүйл бол ямар ч гэрээнд давагдашгүй хүчин зүйл гэж ойлголт байгаа юм. Форс мажорын асуудал тээ. Ер нь нэг давагдашгүй хүчин зүйл гал гамшиг, өөр үнэхээрийн давагдашгүй хүчин зүйл тохиолдоход яах вэ гэдэг заалт байдаг байхгүй юу. Энэ олон малчдын зээлд бол тэр давагдашгүй хүчин зүйлийн асуудал их бүрхэг байв уу. Аль эсвэл банкнууд олгосонгүй юу. Хэрвээ банкнууд олгосон бол гэрээнийхээ дагуу тэр давагдашгүй хүчин зүйлийн хүрээнд олгосон бол хэдий хэмжээний мөнгө олгосон юм. Та нарт тийм мэдээлэл байна уу.

Хоёр дахь нь хэрвээ олгосон бол даатгалын компанийд бас их дэм болох байсан. Өнөөдөр даатгалын компанийн чинь эрсдэлийн сан хоосорчихсон биш, энэ олон малчид чинь банкнаас зээл авахдаа гэрээ байгуулж байгаа шүү дээ. Өнгөрсөн жил тэгээд зудын дараа явж байхад үнэхээр нүд халтирмаар. Зүүн

аймгууд бол. Тэгээд энэ талын юу өрөөсөө олгогдоогүй гэж ярьж байсан байхгүй юу малчид. Энэ талаар та бүхэнд мэдээлэл байна уу гэж. Тэгээд тодруулж байгаад ахиад 1 тодруулга байгаа. Хариултын чинь дараа.

**Б.Бейсен:** 7 номер хариулья.

**Б.Жавхлант:** Ганбаатар гишүүний асуултад хариулья. 1 дүгээрт нь энэ төрийн татаастай холбоотой асуудал байж байгаа. Өмнө нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль 2014 онд батлагдахдаа эрсдэлийн дээд түвшний Засгийн газар, төр хариуцна гэсэн ийм зохицуулалттай явж байсан юм. Тэгээд 2021 онд нэмэлт, өөрчлөлт орохдоо төрийн оролцох хэсгийг нь хязгаарлаад, “Үндэсний давхар даатгал” ХК буюу төрийн эзэмшлийн компани, эрсдэлийн дээд түвшин, дунд түвшнийг бүрэн хариуцахаар болж өөрчлөгдсөн л дөө. Яах вэ олон улсын шинжээчдийн зүгээс бол энэ төрийн оролцоо бол ялангуяа энэ гамшигийн эрсдэлийн даатгалын хувьд зайлшгүй байх шаардлагатай гэдэг ийм зөвлөмжийг бол өгдөг. Яг өнөөдрийн түвшинд манай зорилго юу вэ гэхээр 1 дүгээрт байгалийн гамшигтай холбоотойгоор төсөвт ирж байгаа энэ хүндрэлийг илүү нэмэлт ачааллыг бууруулах зорилготой л энэ хуулийн зохицуулалтыг оруулж ирж байгаа гэж ойлгож болно.

Өөрөөр хэлбэл энэ маань гамшиг, ослын дараа даатгалын хамрагдалт хангалттай түвшинд байвал төсөвт ирэх хүндрэл буурах юм гэдэг л ийм зохицуулалт орж ирж байгаа юм.

Хоёрдугаарт нь яг арилжааны банкны зээлийн хувьд яг нөгөө форс мажор буюу давагдашгүй хүчин зүйлтэй холбоотой ийм зохицуулалт байдаггүй юм шиг байгаа юм. Яг үндсэндээ бол зээлийн гэрээ, зээлийн гэрээ маань хэрэглээний зээлийн гэрээ хэрэглээний зээлийн гэрээ маань төлбөрийн хуваарьтай. Яг тийм онцгой зохицуулалт бол байдаггүй харагдсан. Зүгээр өнгөрсөн жилийн тухайд бол Засгийн газраас чиглэл өгөгдсөний дагуу хэрэглээний зээлийн төлөх хугацааг 1 жилээр хойшлуулсан л ийм цаг үеийн шинжтэй арга хэмжээ авсан тийм юм байгаа.

**Б.Бейсен:** Ганбаатар гишүүн тодруулья. Микрофон өгөөрэй.

**Г.Ганбаатар:** Тэгэхээр тэр сүүлийн хариулт чинь ийм байхгүй юу. Ямар ч гэрээнд ер нь бол давагдашгүй хүчин зүйлийн тухай заалт байх ёстой байхгүй юу. Та нар тэр юуныхаа шугамаар бас энийг ярих ёстой. Арилжааны банкнуудтай бас ойлголцох ёстой байхгүй юу. Мэдээж арилжааны банкнуудад нөлөөлж болохгүй л дээ. Тэгэхдээ эд нар чинь зүгээр бас нэг малчдын мэдлэг чадвар, эрх зүйн мэдлэг дутмагийг нь юу яагаад тэр гэрээний заалтыг хийгээгүй байгаа байхгүй юу. Өнгөрсөн жил бол би тийм юм болсон гэж харж байгаа юм.

Хоёр дахь нь тэр уур амьсгалын өөрчлөлтийн индекс гээд. Тэрийг чинь тодруулья. Дээрээс нь энэ даатгалыг нөгөө карбон кредиттэй уях боломж бий юу. Өөрөөр хэлбэл олон улсын хүлэмжийн хий багасгасан талаар өөр Карбон трейдийн зах зээл байна шүү дээ. Үүнийгээ та нар ингээд үүнтэй холбох боломж байна уу. Тийм судалгаа хийж байна уу.

**Б.Бейсен:** 7 номер хариулья.

**Б.Жавхлант:** 1 дүгээрт нь яг энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шинэ индексийн асуудал бол судалгааны түвшинд явж байгаа. Тэр нь юу вэ гэхээр хойд туйлын хүйтэн агаарын урсгалын индекс гэж байдаг юм байна. Тэр нь болохоор зэрэг ер нь бол 98 хувийн яг тийм магадлал бол таардаг. Өөрөөр хэлбэл тэр хойд туйлын хүйтэн уур амьсгалын индекс нь бол яг урьдчилж гарч болдог ийм индекс байдаг юм байна. Тэгээд энэ бол яг одоогийн байдлаар бол судалгааны түвшинд, энийг хэрэгжүүлэх боломжтой гэдэг юмыг сая өнгөрсөн жил Улаанбаатарт хийгдсэн олон улсын зөвлөгөөний үеэр Дэлхийн банкны мэргэжилтэн бол танилцуулсан юм. Тэгэхээр энийг бол бас Дэлхийн банктай хамтраад хүйтэн уур амьсгалын өөрчлөлттэй хойд туйлын хүйтэн уур амьсгалын өөрчлөлтийн индексийг нэмж оруулах боломж байна гэж харж байгаа.

Хоёрдугаарт нь яг тэр нөгөө нэг энэ даатгалын биш ээ, нөгөө зээлийн гэрээтэй холбоотой энэ форс мажорын асуудлыг бол яг энэ зохих шугамаараа бид нарын хувьд ч бас энэ өөрсдийнхөө шугамаар.../минут дуусав/

**Б.Бейсен:** 7 номер гүйцээж хариульяа.

**Б.Жавхлант:** Үндсэндээ тэрийг бид нар ажлынхаа шугамаар бас танилцуулах ёстой. Карбон трейдтэй холбоотойгоор бид нарын хувьд яг энэ даатгалын бүтээгдэхүүнтэй холбоотойгоор уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг цорын ганц даатгалын бүтээгдэхүүн бол одоо бид нарт байж байгаа малын индексжуулсэн даатгалын бүтээгдэхүүн юм байна лээ.

Малын индексжуулсэн даатгалын бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэх явцдаа малын тоо толгойг чанаржуулах замаар бууруулж ирэх юм бол энэ карбон трейдийн зах зээлтэй бас холбогдох ийм боломж бололцоо байна гэдэг ийм зүйлийг олон улсын яг энэ ногоон санхүүжилтийн чиглэл дээр ажиллаж байгаа байгууллагуудтай харилцаад бол боломжтой гэсэн ийм хариулт өгөөд байгаа юм.

**Б.Бейсен:** Болдын Уянга гишүүн асуулт асууяа.

**Б.Уянга:** Хэдэн тодруулах зүйл байна. Эхнийх нь болохоороо энэ хуулийн төслийн 7.2-т тусгасан давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх компани нь тэрийн болон хувийн хэвшлийн оролцоотой ийм компани байна гэсэн байна л даа. Тэгээд түрүүн бас та хариулахдаа халти дурдах шиг боллоо. Олон улсын байгууллагуудын зөвлөмж, янз бүрийн байгалийн гамшгийн эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаанд тэрийн оролцоо байх ёстой гээд. Тэгэхдээ одоо эрүүл мэндийн даатгалууд хувийн компаниуд даатгалын компаниуд гараад амжилттай хэрэгжиж яваа. Тэгээд саяхан Гурван гол эмнэлгийн сайт дээр тавигдсанаар бол 5 даатгалын компанийг Мандал, Миг, Нэйшнал лайф, Хаан, Монгол Даатгал гээд тавьж өгсөн байна л даа. Тэгээд эд нар нь анх Мандал даатгалаар эхлээд ингээд 5 болтлоо өргөжсөн байна гэхээр хувийн даатгалын компаниуд эрсдэлээ үүрээд явах боломжтой байна. Тэгэхээр 2014 оноос хойш танай энэ хууль батлагдсанаас хойш хамрагдалт угаасаа бага байгаа. Төрийн зохицуулалт ер нь байх шаардлагатай юм уу гэдэг дээр хариулт өгөөч.

Тэгээд энэ дээр хэрвээ судалгаа хийгдээгүй байгаа бол тэр олон улсын зөвлөхүүдээсээ төрд энэ малын индексжуулсэн даатгалын асуудлуудыг оногдуулахгүйгээр, хуваарилахгүйгээр хувийн хэвшилд хэрвээ зохицуулалтыг нь өгөх тохиолдолд ямар эрсдэлүүд учрах вэ гэдэг дээр нь судалгаа хийлгэх хэрэгтэй

байна. Хэрвээ хийлгэсэн байгаа бол яагаад заавал төр энд оролцох ёстой вэ гэдэг дээр эхний ээлжид хариулт авья.

Дараагийнх нь болохоороо энэ хууль, хуулийн төслийн 12.5-д заасан байдлаар их олон сангүүд уншигдах юм. Хамтын эрсдэлийн сан л гэх юм, Давхар даатгалын компанийн сан, Алдагдлаас хамгаалах сан би уншаад байгаа нь бүр өөрөө ч цээжээрээ хэлэхэд боломжгүй олон төрлийн сангүүд байна л даа. Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан, Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан гээд. Энэ олон сангүүд бол иргэдэд ойлгомжгүй байдлыг надад ийм байдлыг үүсгэж байгаа юм чинь энгийн иргэдэд бол ойлгомжгүй байдлыг үүсгэнэ гэхэд бол бүрэн итгэлтэй байна. Тэгэхээр яагаад заавал ингэж олон сангүудад хуваах ёстой юм бэ. Эдгээрийгээ нэгтгээд, төрлөөс нь хамаараад буцаж олох нөхөн олговортойгоо ч юм уу уяд арай ойлгомжтой байдлаар тайлбарлах ёстой байсан биш үү. Энэ 2 дээр эхлээд хариулт аваад, дараа нь тодруулья.

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. 7 номер.

**Б.Жавхлант:** Уянга гишүүний асуултад хариулья. 1 дүгээрт нь яагаад энэ төрийн зохицуулалттай малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүн байх ёстой вэ гэдэг асуудал байгаа юм. Үндсэндээ бол малыг даатгалд хамруулсан түүхийг ярих юм бол 1967 оноос хойш эхлэлтэй. Нэгдлийн малыг тухайн үед нь бол даатгалд хамруулж байсан. Харамсалтай нь энэ тогтолцоо маань 1991 он хүртэл хэрэгжээд, түүнээс хойш бол малын даатгал огт байхгүй болчихсон юм. Өөрөөр хэлбэл дампуурсан гэж ойлгож болно.

1 дүгээрт нь энэ нь юу вэ гэхээр төрийн оролцоо байхгүй учраас энэ бол асар их алдагдалтай учраас хувийн хэвшил ийшээ орохоос бүрэн татгалзсан гэсэн үг. Тийм учраас 2 дугаарт нь даатгалын нөхөн төлбөр буюу малын хорогдлын хувь хэмжээг хувийн компаниуд өөрийн шугамаар тогтоох боломж нь бол байхгүй болчихсон. Өөрөөр хэлбэл нөхөн төлбөрийг тооцох зардал асар өндөр гараад эхэлсэн гэсэн үг. Ийм учраас энэ даатгалын бүтээгдэхүүн бол үндсэндээ зогссон.

2005 онд Дэлхийн банкны мэргэжилтнүүд Монголд ирээд энд малын даатгал яагаад явдаггүй юм бэ гэдэг асуудлыг бол хийгээд судалгаа хийхэд бол хамгийн түрүүнд гаргасан дүгнэлт нь бол асар өндөр зардалтай юм байна.

2 дугаарт нь эдийн засгийн хувьд үр өгөөжгүй юм байна. Одоо яг байж байгаа малчны хотонд гардаг хохирлын даатгалын тогтолцоо. Ийм учраас малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог бий болгоё. Ингэхдээ төрийн оролцоог хангаж өгье. Ингэхдээ төр, хувийн хэвшлийн хамтарсан системийг бий болгоё. Мөн түүнчлэн ингэж өгснөөрөө даатгалын эрсдэл хуваарилах зарчмыг эрсдэлийн дээд, дунд, бага түвшний 3 эрсдэлд хуваагаад, ингэснээрээ бас нөгөө эрсдэлийн бага түвшний малчин өөрөө хариуцах дунд, дээд түвшнийг нь даатгал, давхар даатгал, төр хариуцах эрсдэлийн системийг бий болгож оруулаад, даатгалын компаниуд бол зөвхөн өөрийнхөө даатгалын цуглувансан хураамжийн хэмжээнд эрсдэлийг үүрэх зохицуулалтыг оруулж өгснөөр даатгалын компаниуд оролцох боломжтой болсон юм.

Хэрвээ яг одоо бусад уламжлалт даатгалын бүтээгдэхүүнтэй адил хэмжээгээр эрсдэлийг нь 100 хувь үүрүүлэх юм бол хувийн хэвшлийн даатгалын

компаниуд энэ даатгалын бүтээгдэхүүнд оролцох боломжгүй гэдгээ бол тэр нь бол маш тийм тодорхой үр дүн байгаа юм.

Дараагийнх нь болохоор энэ сангудын асуудал байгаа. Энэ сангуд болохоор үндсэндээ бол яах вэ, олгогдох хэлбэр нь малчдад очиж байгаа. Яг үндсэндээ бол техникийн буюу мэргэжлийн ойлголттой холбоотой эрсдэлийн дээд, дунд түвшинд эрсдэлийн сангаа тус тусад нь байгуулж өгч байж, олон жилийнхээ нөгөө хохирол даах актуарын тооцооллын үндсэн дээр нөөц сан байгуулах мэргэжлийн л холбоотой ийм заалтууд байгаа юм л даа. Тэгээд алдагдлаас хамгаалах сан гэдэг бол эрсдэлийнх нь дээд, дунд түвшний эрсдэлийн санг дууссан тохиолдолд алдагдлаас хамгаалах сангаас нөхөн төлбөр олгоно. Эрсдэлийн дээд, дунд түвшнийх нь болохоор зэрэг 6-30 хувийг нь дунд түвшний эрсдэлийн нөөц сангаасаа нөхөн төлбөр олгох, 30-аас дээш гарсан хэсэгт нь дээд түвшний нөхөн олговрыг дээд түвшний сангаас нөхөн олговор олгох тус тусдаа сангийн зохицуулалтыг оруулж л өгсөн. Ийм мэргэжлийн л холбоотой заалттай юм л даа.

**Б.Бейсен:** Уянга гишүүн тодруулъя.

**Б.Уянга:** Энэ олон сангуд мэдээж учиртай болоод л хуульд орсон байх л даа. Тэгээд тэрийг ингэж асуудаг нь бас мэдээлэл, таны тайлбараар олон нийтэд хүрэх байх гэдэг хүрээнд бол асуусан байгаа юм шүү.

Тэр эхний хувийн хэвшлийнхэн яагаад энэ даатгалд орох боломжгүй юм бэ гэдэг дээр бас хангалттай бүгдээрээ судлаагүй юм шиг санагдаад байх юм. Та 1991 оны асуудлыг ярилаа. 2005 оны судалгааг ярилаа. 2014 оны одоо энэ хууль, хуульд орсон заавал тэрийн оролцоотой байна гэсэн энэ зохицуулалтыг бас өмнө нь ч гэсэн дурдсан. Тэгэхээр 2005-аас өнөөдрийн хооронд бол маш олон жилийн ялгаа байдаг. Шинжлэх ухаанд олон арга аргачлалууд нэвтэрчихсэн байдаг. Тэгээд тэр бүгд нь ингээд тухайн үедээ зогсоод үлдчихээд, тэр нь л хариулт юм гээд байж бол болохгүй байх. Тэгэхээр 2014 оны хуульдаа тэрийн оролцоо байна гээд оруулаад өгчихсөн учраас угаасаа хувийн хэвшил орох боломжийг нь хаачхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээрээ та хэд дахиж судлах хэрэгтэй, үзэх хэрэгтэй. Ийм бол саналтай байна. Дахиад .../минут дуусав/

**Б.Бейсен:** Уянга гишүүн 1 минут.

**Б.Уянга:** Сүүлийнх нь болохоороо танай энэ танилцуулга бол их сайн бэлтгэгдсэн байх шиг байна. Энэ танилцуулга дээр тэгэхдээ зудын өнөөгийн давтагдал, ирээдүйн өөрчлөлт гэдэг дээр Монгол орны уур амьсгалын ирээдүйн төсөөллийг 2030-2080 он хүртэл авсан байна л даа. 2030 он хүртэл ямар төсөөлөлтэй байгаа юм. Тэгээд ер нь бол аливаа ийм төсөөллүүд дандаа нэмэх, хасахтай явдаг. Хэзээ ч төсөөлөл яг түүгээрээ явна гэж угаасаа байдаггүй. Тэгтэл ингээд бүхэл бүтэн 55 жилээр авч үзэж байж, ерөөсөө нэмэх 10 байна гээд л. Тэгэхээрээ нэмэх, хасахтай яг энийг нэг тийм ядаг юм зөвлөхүүд аваад, Монголд энэ судалгааг хийчих хүмүүс зөндөө л байгаад байгаа. Энэ дээр тэрийнхөн маань өөрсдийнхөө бас чадвар чадамжийг сайжруулбал төрд ажиллаж байсан хүний хувьд бол та хэдийг бол дандаа өмөөрч бол ярьдаг шүү. Тэгээд чадлынхаа хэрээр бүх боломжоороо ажиллаж байгаа. Гэхдээ нэг арай өөр өнцгөөс нэг харуулаад үзээрэй. Тэгэхдээ миний асуулт бол 2030 он хүртэл энэ зуны өнөө.../минут дуусав/

### Б.Бейсен: 7 номер хариулья.

**Б.Жавхлант:** Уянга гишүүнтэй санал нэг байна. Саяын энэ гаргаж байгаа тооцоолол бол үндсэндээ 2030-2080 оны хоорондох зудын буюу байгалийн гамшгийн эрсдэл, ялангуяа мал аж ахуйн салбарт нөлөөлөх нөлөөллийн судалгааг Ус, цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс гаргасан судалгаа байж байгаа.

2030 он хүртэлх богино хугацааны зудын зураглал одоогийн түвшинд бол яг энэ танилцуулгад ороогүй байгаа боловч Ус, цаг, уур орчны шинжилгээний хүрээлэнгээс 3-5 жилийн давтамжтай зудын эрсдэлийн урьдчилсан таамаглалыг бол гаргадаг юм байна лээ. Тэгээд тэр мэдээлэл бас бид нарт байгаа. Тэгээд таны хэлж байгаа нөгөө дээшээ, доошоо, нэмэх, хасах хэлбэлзэл бол зайлшгүй байх ёстой. Энэ дээр бол санал нэг байгаа. Тэгээд яах вэ, энэ танилцуулгад орохдоо бас ингээд орчихсон юм байгаа байх зүгээр. Ус, цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс гаргасан энэ судалгааны түвшинд бол бид нарт мэдээллүүд байгаа. Зудын давтамж бол .../минут дуусав/

### Б.Бейсен: Гишүүд асуулт асууж дууслаа.

Би нэг юм асуугаадахъя. Энэ нийт хураамж нь 37,4 тэрбум болсон байна. Тийм ээ, зарцуулалт нь 29,4 тэрбум. Цаана нь 8 тэрбум танай нөөцөд байгаа юу 1 дүгээрт. Сангийн яамныхан бас ярьж байгаа. Гэтэл энэ индексийн даатгалд даатгуулдаг малчин өрхийн тоо 16 хувьтай юм байна. Даатгалд хамаардаг мал сүргийн 9 хувь нь байна. Тэгэхээр энийг цаашдаа нэмэгдэнэ гэж тооцоолж байна уу. Одоо зудыг эрс тэс, эрт хамгаалахын тулд өвс тэжээл бэлдэх асуудлыг жишээлбэл 8 тэрбум төгрөг танай санд байгаа юу. Энэ талаар асууя. 7 Номер

**Б.Жавхлант:** Бейсен гишүүний асуултад хариулья. Үндсэндээ сүүлд өнгөрсөн яг хууль батлагдсанаас хойш 10 жилийн үр дүнг аваад үзэхэд нийтдээ 37,4 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг малчин иргэдээс цуглуулсан байгаа. Үүнээс 29 тэрбум төгрөгийг даатгалын нөхөн төлбөр хэлбэрээр даатгуулагч малчдад олгосон. Энэ даатгалын гэрээг борлуулахтай холбоотойгоор зардал бол нэлээн өндөр гардаг. Зардлын түвшинг бид нар 30 хувиас илүү байхгүйгээр хязгаарлаж өгөх энэ зохицуулалтыг Хамтын эрсдэлийн сангийн журам гэж баталдаг юм. СЗХ, Сангийн яамны хамтран баталдаг энэ журмын дагуу. Тэгэхээр 30 хувийн зардал гэдэг бол бас нөгөө тухайн малчин иргэндээ очиж малын даатгалыг борлуулах түвшинд бол бас хангалттай түвшний зардалд хүрдэггүй тийм сөрөг тал байдаг л даа. Ийм учраас бас нөгөө даатгуулагч малчин иргэдийн хувьд нөгөө ойлгуулан таниулж, соён гэгээрүүлэх ажил бол орхигдож, хоцорч байгаа нь бол үндсэндээ бол энэ зардлын түвшин бага байгаатай холбоотой. Ингээд аваад үзэх юм бол нийтдээ 10-12 тэрбум төгрөгийн зардал бол даатгалын компаниуд бол хамгийн багадаа гаргачаад байгаа юм. Үндсэндээ тэр илүү зөрүүг нь энэ чинь үндсэндээ сүүлийн 10 жилийг хархаар алдагдалтай гэж харж болохоор ийм даатгалын бүтээгдэхүүн харагдаад байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ зөрүү алдагдлыг яж бий болгосон бэ гэхээр “Үндэсний давхар даатгал” компанийн үйл ажиллагааны орлого, ашгийн түвшнээр нөөц сангаа нэмэгдүүлж байсны л хөрөнгө оруулалтын өгөөжөөр л бид нар энэ нөхөн төлбөрийг олгож чадсан гэж ийм дүр зураг харагдана.

**Б.Бейсен:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан санал хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгөөрэй.

Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Замира гишүүн, Ганбаатар гишүүдийг нэмье. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн санал хэлье.

**Б.Бат-Эрдэнэ:** Уг нь бол 2022 оны 6 сард Засгийн газрын хуралдаанаар танайхыг одоо ХК 34 хувь хүртэлх хувийг олон нийтэд санал болгож гаргах ийм шийдвэрийг гаргасан байдаг. 2023 оны 3 сарын 31-ний өдөр би андуураагүй бол СЗХ-оос анхдагч зах зээлд арилжаалах зөвшөөрлийг олгосон. Одоо бараг 2 жил болох гэж байна. Тэгээд өнөөдөр энэ оруулж ирж байгаа нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудал дээр ч гэсэн би яагаад энэ тандан судлах үнэлгээний тайланг хэлээд байгаа вэ гэхээр хуулийн нэмэлт, өөрчлөлт хийх зайлшгүй шалтгаан энэ дотор байгаа байхгүй ю.

Тэгээд ер нь бол түрүүн Уянга гишүүн ч гэсэн бас ер нь хэлчихлээ л дээ. Ганхүлэг гишүүн ч гэсэн хэлчихлээ. Хувийн байх, төрийн байх 2-ын ялгаа энэ дээр маш өндөр харагдаад байгаа юм. Танай үндсэн зорилго чинь бол анх олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, дотоодын даатгалын компаниудыг давхар даатган ажиллах зорилго бүхий хөдөө аж ахуйн давхар даатгалаар байгуулагдаж байсан. Сүүлд “Үндэсний давхар даатгал” болж нэрийг нь өөрчилсөн юм шүү дээ. Тэгэхдээ зорилгыг нь өөрчлөөгүй. Тэгээд даатгуулагч нь бага байна. Хүртээмж бага байна гээд л ингээд л гоншигноод л суугаад байх юм. Та нар ажилла л даа. Ажлаа хийх ёстой шүү дээ. Яагаад 2023 оны 3 сарын 31-нд СЗХ-оос анхдагч зах зээл дээр хувьцаа гаргах ХК болох шийдвэр чинь гарчхаад байхад өнөөдөр хүртэл хийхгүй яваад байгаа юм. Одоо процесс явж байгаа л гэж та нар хэлэх байх.

Гэтэл нөгөө талдаа түрүүн Батжаргал гишүүний хэлсэнчлэн бас нийт малчин өрхийн чинь 11-18 хувь л хамрагдаж байна. Нийт малын чинь 7-10 хувийг л даатгуулж байгаа юм. Байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой асуудлаас төрийн үзүүлэх үйлчилгээ гэдэг юм уу эсвэл төрийн даах ёстой ажил үүрэг гэдгийг ойлгож байна. Тэгэхдээ энэ хэрвээ хувийн хэвшил байсан бол өнөөдөр та нар шиг ажиллахгүй байхгүй ю. Магадгүй төрийнх учраас ийм удаан, магадгүй өнөөдөр төрийнх учраас хүмүүс, малчид ерөөсөө хамрагдахгүй байна, малчид энийг ойлгож өгөхгүй байна. Ойлголт их дутуу байна гэдгээрээ заавал жишээлбэл төрөөс үзүүлж байгаа хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй зээлд нь хамруулж байгаад малчдыг ялангуяа малын индексжуулсэн даатгалд заавал хамруулах албан журмын даатгал шиг юм хийх гээд байна шүү дээ. Тэгээд энэ болохгүй ээ. Дараа нь та нар энэ хуулиа өөрсдөө үзээрэй. Засгийн газар нөгөө юуг чинь хийчхэж байгаа юм. Индексжуулэлтийн асуудлууд. Нөгөө босгыг өөрчлөх. Засгийн газрын хуралдаанаар оруулж өөрчилж байгаа юм. Саяын Жолоочийн даатгалын тухай хууль шиг СЗХ-оос магадгүй индексийг нь өөрчлөөд, дахиад нэг томоохон хэмжээний хураамжийн нэмэгдлүүд болбол яах вэ. Дахиад л асуудал үүснэ.

Тэгээд түрүүн бас тайлбарлаж байгаа тайлбарууд чинь маш дутуу хэллээ. Он дамждаг гэдгийг бид нар ойлгож байна. Энэ чинь өвөл чинь угаасаа л он дамжиж байгаа шүү дээ. Тэгэхдээ та нар энэ тогтолцоогоо өөрчлөхийн төлөө ажиллахгүй, даатгалынхаа хүртээмжийг яаж нэмэгдүүлэхийг хуульчилж оруулж эрх зүйн орчныг нь өөрчилж байж энэ даатгалын даатгуулагчийн тоог нэмэх вэ гэдэг дээр л илүү анхаараад байна шүү дээ. Малчдад яаж энэ ойлголтыг илүү түлхүү өгөх вэ, эрх зүйн орчныг нь тэр тал дээр яаж явуулах вэ, яаж энэ ХК болгож нээлттэй ХК болгох вэ гэдэг дээрээ анхаар л даа..../минут дуусав/

## Б.Бейсен: Ганхүлэг гишүүн үг хэлье.

**М.Ганхүлэг:** Би бас асуултдаа бүрэн бас хариулт авч чадсангүй ээ. Тэгэхдээ яах вэ дараа дараагийн хэлэлцүүлгүүд бас байгаа байх. Асуудлыг бас тал талаас нь ярих нь зөв байх гэж бодож байна. Төрийн оролцоотой, ашгийн төлөө тэгээд яг малчдын яг эрсдэлийн энэ хүнд цаг үед нь бас тодорхой тус дэм болох энэ чиглэлээ үндсэн эрхэм зорилгоо болгож ажиллахгүй. Бид нар ашгийн төлөө ажилладаг байгууллага гээд байж байх нь зөв үү, буруу юу. Хэдүүлээ бас яг л сүүлийн 10 жилийн хугацаанд иргэд, малчдын хувьд бол энэ даатгалд сэтгэл ханамж бол бас тийм өндөр биш байгаа л даа. Тэгэхээр эндээ яг ийм сайжруулсан шийдлүүд яг юу байна вэ гээд нэмэлт, өөрчлөлт орж ирэхээр яг л өөрсдийнхөө хувьд илүү давуу байдал авсан босго оноо энэ зүйлүүд нь бас тодорхойгүй Засгийн газрын түвшинд бид нар өөрсдөө ярилцаж байгаад, бууруулахаар бол оруулж ирнэ гээд. Нөгөө талаараа нэмэгдүүлчхэж болохоор ийм эрхийг л авах гээд байгаа юм шиг л ингэж харагдаад байгаа болохоор л жоохон эмзэглээд ингээд бас хэлээд байна л даа. Тэгэхээр зоригтойгоор яг энэ малчид иргэдийнхээ энэ саналыг харгалзаж үзээд, тэр хамрах хүрээг нь бууруулаад тодорхой хувь хэмжээг нь бууруулаад тэгээд энэ даатгалын компанийг ашгийн төлөө гэхээсээ илүүтэй малчид иргэдийнхээ төлөө байх энэ агуулга руу нь оруулсан хэлбэр лүү ер нь оруулбал яасан юм бэ л гэдэг энэ саналыг л би асуугаад бас хэлэх гээд байгаа юм л даа.

Тэгээд тодорхой хэмжээнд ашиг орлого олж байгаа юм бол энэ ашиг орлогынхoo тодорхой хэсгийг нь эрсдэлийн сандаа оруулаад үлдсэнээр нь идэвхтэй даатгуулж байгаа иргэдээ заавал хохирол амсаагүй ч гэсэн тодорхой хэмжээнд урамшуулдаг, энэ чиглэлийн зүйлүүдийг нь бол дэмждэг. Яг л энэ малчдын эрсдэл, асуудлуудыг бас дэмжих чиглэл рүүгээ анхаарсан, төрийн оролцоотой энэ агуулга шийдэл нь ч гэсэндээ тодорхой ийм корпорац болгоод хөгжүүлбэл яасан юм бэ гэдэг л ийм л энгийн саналыг бас хэлээд байгаа юм.

Тэгэхээр дараа дараагийн шат дээр жоохон сайжруулах тал дээр нь эдгээр зүйлүүдийг бас хэдүүлээ анхааръя. Энэ босго оноог шинэчилсэн орчин үеийн шийдлээр бид нар өөрсдөө мэдээд хийнэ гэдэг энэ агуулгаасаа илүү тодорхой бууруулах чиглэл рүү нь бас оруулбал яасан юм бэ гэдэг зарчмын саналуудыг бас оруулмаар байна.

Дээрээс нь энэ даатгалд бас малчид маань бол өөрсдийн сайн дураараа даатгуулах энэ байдлыг нь бас хэтэрхий хэдүүлээ бас булааж аваад хэрэггүй байх. Бас өөр олон хувилбар зүйлүүд бас байгаа байх. Тэгэхээр ямарваа нэгэн хөнгөлөлт урамшуулал, Засгийн газрын болон бусад арилжааны зээл хууль авахдаа үндэсний давхар даатгалд хамруулсан байх ёстой гэдэг энэ хуульчилсан заалтыг оруулах нь бас яг энэ цаг үед энэ бас зохимжтой юу, үгүй юу гэдгийг бас дахиж энэ харах шаардлагууд бас байна гэдэг энэ саналуудыг би бас тэмдэглүүльье.

Дээрээс нь зөвхөн энэ давхар даатгалын системээс гадна өөр ямар хувилбарууд байж болох вэ гэдэг тухай бид нар бас ярих цаг болсон. Илүү чөлөөлөх, олон сонголттой болгох, иргэд, малчид маань бас энэ эрсдэлээс хамгаалах энэ боломжууд нь зөвхөн нэг ийм санал бид нарт тавихаасаа гадна өөр давхар боломжуудыг бий болгох чиглэлээр хувийн хэвшлүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт, агуулгууд илүү сайжирч орж

ирээсэй гэдэг ийм бас байр суурьтай байгаа учраас жоохон бухимдаад, энийг сайжруулахын төлөө бас асуулт саналаа бас хэлээд байгаа шүү. Тэгээд дараа дараагийн хэлэлцүүлгүүд дээр илүү детальчлаад бас ярилцах болов уу гэж бодож байна.

Зүүн бүстэй холбогдолтой яг мэдээллийг Жавхлант дарга бас яг над руу хаяглаад боломжтой бол бас өгөөрэй. Сүүлийн 2 жилийн хугацааны мэдээллийг. Энэ дээр бас тодорхой анализ хийгээд бас илүү сайжруулаад ажиллаж гэсэн ийм саналтай байна.

**Б.Бейсен:** Ганбаатар гишүүн үг хэлье.

**Г.Ганбаатар:** Би бол ганцхан л санал хэлмээр байгаа юм. Ер нь энэ даатгалын ач холбогдлыг л их сайн ойлгуулах, малчдад ч тэр дээрээс нь хөдөө аж ахуйн салбарт ч тэр ойлгуулах их чухал ажлыг л далайцтай хиймээр санагддаг юм. Ерөөсөө энэ хүн төрөлхтөн чинь өнгөрсөн хугацаанд эрсдэлээс сэргийлэхээр олж сэтгэсэн ганц арга нь л ер нь даатгал шүү дээ. Хамтын дундаа л эрсдэлээ хувааж байгаа хэлбэр. Тэгээд үүнийг л ойлгуулах талаар энэ “Үндэсний давхар даатгал” нь байна уу, Хөдөө аж ахуйн яам нь байна уу, өнөөдөр энд сууж байгаа та нар ажлын хэсэг байна уу, үүнийгээ сайн ойлгуулж, сурталчлах ажил их дутмаг юм уу л гэж бодогддог юм. Мэдээж энэ зөвхөн та хэд биш л дээ. Ингээд Монголын төр, аймаг орон нутгийн удирдлагууд, сум, багийн удирдлагууд бүгд л хийж байх ёстой. Яг энэ ойлголт нь гайгүй болоод ирвэл манай хөдөө аж ахуйн салбар бас тодорхой хэмжээний эрсдэлээс сэргийлээд, бас эрсдэлээ хуваалцаад байх боломж бүрдэнэ л гэж бодож явдаг юм.

**Б.Бейсен:** Замира гишүүн үг хэлье.

**С.Замира:** Баярлалаа. Зарим нэг саналууд давхцаад байна. Сая Ганбаатар гишүүний хэлсэн, тэгээд Уянгаа гишүүн, Ганхүлэг гишүүдийн хэлсэн саналд би ч бас дэмжиж байна. Маш зөв санаанууд ярьж байна шүү. Тэрийг бас анхаарах хэрэгтэй. Уг нь малчдад ойлголт өгөх хэрэгтэй. Татгалзвал ингэнэ, дараа нь ийм өгөөжтэй байгаа, даатгалд албадах маягтаа ингээд хурааж авна гэснээс эхлээд сайн ойлгуулж, ард түмэнд ингээд дараа нь ямар нэг эрсдэлд орсон нөхцөлд энэ өгөөжтэй гэдгийг сайн ойлгуулах хэрэгтэй. Боловсрол л өгөх хэрэгтэй малчдад. Тэгж байж даатгуулах талаар нь ярихгүй бол хууль баталчхаад цаашаа явна гэвэл явахгүй шүү.

Тэгээд 2 дугаарт энэ даатгалын компаниуд гэж авахдаа гарамгай. Машин техникийн даатгалын байдлыг харж байхад маш хурдан авчихна. Даатгалыг. Тэгээд буцаад эрсдэлд гэхэд буцааж төлөхөд их чирэгдэлд ордог шүү дээ жолооч нар. Удаан хугацаагаар явна. Тэгээд малчид бол тэгж явах боломж байхгүй шүү. Хөдөө малааmallaa маллаа юм уу, даатгалын компанийн хойноос явах юм уу. Тийм учраас энэ эргэх холбоо гэдэг юм ер нь байнга байх ёстой. Оффист сууж байгаад малчдын асуудлыг шийднэ гэвэл бүтэхгүй. Заавал малчдад очиж байдлыг нь нүдээрээ харж, өөрсдөө үйлчлэх л ёстой даатгалын компани бол. Энийг та хэд маань цаашид анхааралдаа авна уу гэдэг санал байна. Баярлалаа.

**Б.Бейсен:** Надад нэг санал байна. Байнгын хорооны даргын хувьд танайх бол Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан төрийн өмчтэй компани тийм ээ. Тэгэхээр энэ санхүүжилтийг бас улсын төсвөөр санхүүжиж байгаа байх. Тийм биз

дээ. Ямар хэлбэрээр санхүүжиж байдаг юм. Өөрийн орлогоор уу. Тэгэхээр энэ саяын зарцуулалт тэр 8 тэрбум төгрөг одоо ингээд сурталчилгааны ажилд зарцууллаа гээд ярьж байна. Тэгэхдээ энийг бид бас лавлая. Индексжуулсэн даатгалд хамрагдаж байгаа малчин өрхийн зөвхөн 16 хувь нь юм байна. Даатгалд хамрагдаж байгаа малын 9 хувь нь юм байна. Тийм учраас Болорчулуун дарга энэ юун дээр бас хяналт тавьж ажиллаад, малчдыг сурталчлах талын асуудал дээр манай Байнгын хороотой хамтраад ер нь эрчимжүүлэх тал дээр анхаarahгүй бол энэ Сангийн яамныхан байна. Энэ Сангийн яамны бодлогын газрын дарга ирсэн байна. Мөн СЗХ-ныхон ирчихсэн байна. Энэ компани чинь уг нь Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан төрийн өмчт компани гээд ойлгоод байгаа шүү дээ. Уг нь санхүүжилт авч байгаа байх гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхдээ энийг бид нараас асууя. Тэгэхээр энийг эрчимжүүлээд, малчдыг олноор хамруулах талын асуудал дээр анхаarahгүй бол жаахан тааруухан ажиллаж байна уу гэсэн дүгнэлттэй л байна.

Яагаад гэвэл ингээд байгуулагдаад хэдэн жил болчихсон байхад зөвхөн энэ индексжуулсэн даатгалд 16 хувь нь хамрагддаг, нийт малынх нь 9 хувь нь хамрагддаг. Тэгээд энэ талын асуудал дээр бас хамтарч ажиллахыг та бүгдийг уриалж байна. Нөгөө талаар аймгуудын хөдөө аж ахуйн газрынхан ирчихсэн байна. Нөгөө талаар өнөөдөр бүх аймгуудын хурлын дарга, Засаг дарга нар ирчихсэн байна. Тэгээд энийг эрчимжүүлэх тал дээр сайн ажил болговол орно зуд, юуны эрсдэлийн үед бас хэрэгтэй л байх гэж бодож байна малчдад.

Гишүүд уг хэлж дууслаа. Санал хураалт явуулья.

Малын индексжуулсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. Бат-Эрдэнэ гишүүнийг дэмжсэнээр авъя. 52,9 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Б.Бат-Эрдэнэ гишүүн танилцуулна.

11.15 цаг.

Дараагийн асуудалд орьё. 3 дугаар асуудал.

**“Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын байгаа.**

Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун Байнгын хорооноос байгуулагдсан “Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах зохион байгуулах үүрэг бүхий” ажлын хэсэгт орж ажиллах талаар хүсэлт тус Байнгын хороонд ирүүлсэн.

Тогтоолын төслийг танилцуулъя. “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын

тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэл хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууныг нэмсүгэй гэсэн тогтоолын төсөл байгаа.

Тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. 58,8 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

11.17 цаг.

**Дараагийн асуудалд орьё. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Тогтоолын төслийг танилцуулъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.10 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчаар Ж.Бат-Эрдэнэ- Монгол Улсын Их Хурлын гишүүн

Гишүүдэд М.Ганхөлөг, С.Замира гишүүн, У.Отгонбаяр гишүүн, С.Ганбаатар гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтыг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг /Ж.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга /Б.Бейсен/-д даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байгаа.

Тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. Санал хураалтыг түр түдгэлзүүлье. Ганхүлэг гишүүн.

**М.Ганхүлэг:** ЖДҮ-ийн ажлын хэсэг тийм ээ. Энэ дээр одоо нөгөө 54 ажлын хэсэг байгуулагсан байгаа шүү дээ. Батлут гишүүн бас ахалсан ажлын хэсэг байгаа. Тэгэхээр тэр ажлын хэсэгтэй бас уялдаа холбоог нь яаж хангаж ажиллах ёстой вэ. Давхардаад ингээд ажлууд нь явах уу. Эсвэл хоорондоо ойлголцод бас ингээд ажил төрлөө салгах уу.

2-т нь бусад гишүүдээс бас манай Байнгын хороонд байхгүй ч гэсэн бусад гишүүдээс орох саналууд бас их хэлж байгаа юм байна. Манай зүүн бүсээс

Бадамсүрэн гишүүн бас энэ чиглэлээр тодорхой саналууд гаргаад, Засгийн газрын төлөвлөгөө юмнууд бас оруулаад явж байсан. Тэгээд түүнтэй холбогдолтой асуудлаараа ажлын хэсэгт ороод ажиллах саналтай байх шиг байна лээ.

Тэгэхээр ийм бусад гишүүдийг Байнгын хорооны ажлын хэсэгт оруулж болдог юм уу. Оруулбал яах ёстой вэ гэдэг ийм 2 асуулт.

**Б.Бейсен:** Энэ орох эрх нь нээлттэй байгаа. Өөрсдөө санал ирүүлээгүй байгаа. Нөгөө талаар манай Байнгын хорооны хариуцаж байгаа ажлын хүрээнд бас энийг хэрэгжилтээр нь яагаад л эргэн төлөлтийн асуудал дээр анхаарахгүй бол энэ жил бас төсөв дээр ийм юм тавигдаагүй. Ер нь ЖДҮ-ийн тэр аймгууд дээр зээлийн хуваарилалтын асуудал дээр анхаараад, санал, дүгнэлтээ гаргаад бид нар бас өгөх ёстой доо. Энэ жил тийм юм тавигдаагүй шүү дээ. Эргэн төлөлт дээр 100-аад тэрбум яах байх гээд л Хөдөө аж ахуйн сайд яриад байгаа. Тэгэхдээ энэ дээр анхаараад, манай хариуцаж байгаа Байнгын хорооны хүрээнд бас дүгнэлт гаргаад, дараагийн юун дээр тодорхой хэмжээний төсөв тавиулах тал учраас бид нар ийм асуудал тавьж байгаа юм.

Манайх Байнгын хороогоос бас дүгнэлтээ гаргана. Тэр хариуцсан ажлын хүрээнд. Нөгөө тал дээр бас хэлэлцэж байгаа ЖДҮ-ийн асуудал дээр бас бид нар саналыг бас сонсьё. Бадамсүрэн гишүүн саналаа илэрхийлчихвэл нэмчхэж болж байна. Танд хэлсэн юм уу.

Одоо саналаа хураачихъя. Бадамсүрэн гишүүнийг бас энэ ажлын хэсэгт оруулаад, санал хураалт явуулчихъя. 52,9 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны хурал хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа. Гишүүдэд баярлалаа.

11.22 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ